



# МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2022 оны 2 дугаар  
сарын 8-ны өдөр

Дугаар 14

Улаанбаатар  
хот

## Ажлын хэсэг байгуулах тухай

1. Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын бүтээн байгуулалтын ажлыг удирдан зохион байгуулах, хэрэгжилтийг эрчимжүүлж, шуурхай арга хэмжээг тухай бүр авч, дэмжлэг үзүүлж ажиллах Ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

- Дарга: -Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар
- Дэд дарга: -Сангийн сайд Б.Жавхлан
- Гишүүд: -Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр;
- Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг;
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд  
А.Ариунзаяа;
- Эрчим хүчний сайд Н.Тавинбэх;
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон;
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайд  
Б.Бат-Эрдэнэ;
- Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга Д.Ганзориг;
- Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, Улсын  
онцгой комиссын шуурхай штабын дарга  
Б.Ууганбаяр;
- Нийслэлийн Засаг даргын орлогч Б.Одсүрэн;
- Дархан-Уул аймгийн Засаг дарга Б.Азжаргал;
- Сэлэнгэ аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж;
- Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар;

-Сангийн яамны Хөгжлийн санхүүжилтийн газрын дарга И.Батхүү;


-Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Н.Ууганбаяр;

-Замын-Үүд боомтын зөвлөлийн дарга, Хилийн 0108-р ангийн захирагч В.Намхайнямбуу.

Нарийн бичгийн дарга:

-Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Оюундэлгэр.

2. Ажлын хэсгийн удирдамжийг хавсралт ёсоор баталсугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Ерөнхий сайдын 2022 оны 14 дүгээр  
захирамжийн хавсралт

## АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын бүтээн байгуулалтын ажлыг удирдан зохион байгуулах, хэрэгжилтийг эрчимжүүлж, шуурхай арга хэмжээг тухай бүр авч дэмжлэг үзүүлж ажиллах Ажлын хэсэг дараахь чиглэлийг баримтлан ажиллана:

1. Азийн хөгжлийн банк болон Европын сэргээн босголт, хөгжлийн банкны зээлийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын нийт 10 багц төслийн барилгын ажлыг гүйцэтгэх нарийвчилсан график төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангуулах;

2. Авто замын барилгын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай ажиллах хүч, мэргэжилтэнг гадаадаас авахад шаардагдах зөвшөөрлийг зохих журмын дагуу олгох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх, гадаад ажиллах хүчнийг Монгол Улсад ирүүлж, ажлын талбайд байрлуулан ажиллуулах асуудлыг шуурхай зохион байгуулах;

3. Авто замын барилгын ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах эрх олгох асуудлыг тухай бүр Засгийн газрын хуралдаанаар шуурхай хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх, авто замын барилгын ажил гүйцэтгэхэд шаардлагатай газрыг түр ашиглах, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах зэрэг орон нутгийн оролцоотой асуудлыг барилгын ажилд саад учруулахгүйгээр шуурхай шийдвэрлэх;

4. Авто замын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх бэлтгэлийг өвлийн улиралд бүрэн хангаж, барилгын ажлыг 2022 оны 3 дугаар сард эхлүүлэх, барилгын ажлыг тасралтгүй, хэвийн үргэлжлэхэд шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авах, төрийн болон нутгийн захиргааны байгууллага хоорондын уялдааг хангаж ажиллах;

5. Авто замын барилгын ажилд ашиглахаар импортоор оруулж ирэх бараа материал, техник, тоног төхөөрөмжийг улсын хил, гаалиар саадгүй, шуурхай нэвтрүүлж, ажлын талбайд саатал, хүлээлт үүсгэхгүй байх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

6. Авто замын барилгын ажлын явц, гүйцэтгэлийн чанар байдалтай улирал тутам, шаардлагатай тохиолдолд тухай бүр газар дээр нь очиж танилцан, гүйцэтгэгч болон зөвлөх компанитай байгуулсан гэрээний хэрэгжилт, тухайн төслийг батлагдсан зураг төсөл, техникийн шаардлагын дагуу гүйцэтгэж байгаа эсэхэд хяналт тавих, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх;

7. Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын барилгын ажлын явц, үр дүнг улирал бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж байх.